



МОНГОЛ УЛСЫН  
ТӨРИЙН ӨМЧИЙН ХОРООНЫ ТОГТООЛ

2009 оны 11 сарын 03 өдөр

Дугаар 391

Улаанбаатар хот


Журам батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйл, Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолыг үндэслэн Төрийн өмчийн хорооноос ТОГТООХ нь:

1. Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулах журмыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Энэ журмыг нийтийн хоол, үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний зориулалтаар төрийн өөрийн өмчийг түрээслэхэд мөрдлөг болгон ажиллахыг Төрийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Л.Ганбат/ -т даалгасугай.



ДАРГА

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Д.СУГАР

Л.ГАНБАТ

## **ТӨРИЙН ӨӨРИЙН ӨМЧИЙН ЭД ХӨРӨНГИЙГ ТҮРЭЭСЛЭХ ТҮРЭЭСЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1. Төрийн өөрийн өмчийг нийтийн хоол, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний зориулалтаар иргэн, хуулийн этгээдэд бүхэлд нь болон хэсэгчлэн түрээслэх, түрээслэгчийг сонгон шалгаруулахад энэхүү журмыг мөрдөнө.

### **Хоёр. Сонгон шалгаруулалтыг зарлан мэдээлэх**

2.1. Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулах /цаашид “шалгаруулалт” гэх/ тухай зар мэдээг Төрийн өөрийн өмчийг эзэмшигч хуулийн этгээд /цаашид “Түрээслүүлэгч” гэх/ нийтэд мэдээлнэ.

2.2. Шалгаруулалтын тухай зар мэдээнд дараахь зүйлийг тусгана. Үүнд:

- а. Түрээслэх эд хөрөнгийн талаархи танилцуулга, хаяг, мэдээллийн талаар лавлагаа авах утасны дугаар;
- б. Шалгаруулалтад оролцогчдын материалыг хүлээн авах эцсийн хугацаа;
- в. 1 м.кв. талбайн түрээслэх үнийн доод хэмжээ;
- г. Үндсэн хөрөнгө түрээслэх үнийн доод хэмжээ.

2.3. Түрээслэх эд хөрөнгийн онцлог, шинж чанарт нийцүүлэн Төрийн өмчийн хороо нэмэлт шаардлага тавьж болох бөгөөд энэ талаар зар мэдээнд заавал тусгасан байна.

### **Гурав. Шалгаруулалтад оролцогчид тавих шаардлага**

3.1. Шалгаруулалтад иргэн, хуулийн этгээд /цаашид “оролцогч” гэх/ оролцож болох бөгөөд тэдгээр нь дор дурдсан шаардлагыг хангасан байна. Үүнд:

- а. Үйл ажиллагаа нь түрээслэх эд хөрөнгийг зориулалтаар нь эзэмших, ашиглахад нийцсэн байх;
- б. Түрээсийн төлбөр төлөх санхүүгийн чадвартай, хөрөнгийн баталгаатай байх;
- в. Материалыг зарласан хугацаанд ирүүлсэн байх;

3.2. Шалгаруулалтад оролцогчдоос гаргасан хөрөнгийн баталгаа нь банк болон бусад иргэн, хуулийн этгээдэд барьцаалуулсан хөрөнгө байж болохгүй.

## **Дөрөв. Оролцогчийн эрх, үүрэг**

4.1. Оролцогч нь зарласан хугацааны дотор материалаа битүүмжилж, өөрөө эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчөөрөө дамжуулан түрээслүүлэгчид хүлээлгэн өгнө. Биеэр болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр хүргэх боломжгүй тохиолдолд зар мэдээнд заасан хугацаанд багтаан баталгаат шуудангаар ирүүлнэ. Бүрдүүлсэн материалын товъёогыг дугтуйны гадна талд бичсэн байна.

4.2. Сонгон шалгаруулах комисс, түүний үйл ажиллагааны талаар томилсон байгууллагад нь гомдол гаргах эрхтэй.

4.3. Шалгаруулалтад ирүүлсэн материалын үнэн зөвийг оролцогч бүрэн хариуцна.

### **Тав. Сонгон шалгаруулах комиссын эрх, үүрэг**

5.1. Сонгон шалгаруулах комисс /цаашид “комисс” гэх/ -ыг:

а. 40 м<sup>2</sup> хүртэлх талбай бүхий төрийн өөрийн өмчийг түрээслүүлэх тохиолдолд Түрээслүүлэгч хуулийн этгээдийн даргын тушаалаар /Комисст Төрийн өмчийн хорооны төлөөллийг оруулна/;

б. 40 м<sup>2</sup> ба түүнээс дээш талбай бүхий төрийн өөрийн өмчийг түрээслүүлэх тохиолдолд Төрийн өмчийн хорооны даргын тушаалаар /Комисст түрээслүүлэгч хуулийн этгээдийн төлөөллийг оруулна/ тус тус томилно.

5.2. Комисс дор дурдсан эрх, үүрэгтэй байна:

- а. Шалгаруулалтыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу явуулах;
- б. Комиссын аль нэг гишүүн тусгайлсан санал гаргавал энэ тухай тэмдэглэлд тусгах;
- в. Түрээслүүлэх эд хөрөнгийн талаар ашиг сонирхолын зөрчилгүй байх;
- г. Үйл ажиллагааныхаа явцад байгууллага, хувь хүний нууцыг задруулахгүй байх.

### **Зургаа. Материал хүлээн авах**

6.1. Зар мэдээнд заасан хугацаанд ирсэн бүх материалыг бүртгэж, тусгай тэмдэглэл хөтөлж хүлээн авна.

6.2. Шалгаруулалтад ирүүлсэн бүх материалыг тусгай тэмдэглэлийн хамт шалгаруулалт явуулах өдөр комисст хүлээлгэн өгнө.

6.3. Комисс нь шалгаруулалтад ирүүлсэн материалыг шалгаж бүрдүүлбэр гүйцэд байна гэж үзвэл хүлээн авах бөгөөд энэ тухай акт үйлдэж гарын үсэг зурна.

6.4. Материал дугуу тохиолдолд шалгаруулалтаас хасна.

### **Долоо. Шалгаруулалтыг дүгнэх**

7.1. Энэхүү журмын 3.1 -д заасан шаардлагыг хангасан оролцогчоос хамгийн өндөр үнийн санал өгсөн этгээдийг шалгаруулна. Энэ үнэ нь Төрийн өмчийн хорооны баталсан төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн 1м2 ашигтай талбайн түрээсийн төлбөрийн доод үнээс өндөр байна.

7.2. Шалгаруулалт дууссанаас хойш ажлын 5 хоногийн дотор шалгарсан иргэн, хуулийн этгээдтэй төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ байгуулна.

### **Найм. Маргаан шийдвэрлэх**

8.1. Сонгон шалгаруулалттай холбогдон гарсан бүх маргааныг хэлэлцээгээр шийдвэрлэнэ. Маргааныг хэлэлцээгээр шийдвэрлэж чадахгүй тохиолдолд хууль тогттоомжид заасны дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

-----oOo-----